

2017 ОНЫ ЭХНИЙ 9 САРД ИРГЭД, БАЙГУУЛЛАГААС ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН САНАЛ, ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ

Нэг. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд 2017 оны эхний 9 сард иргэд, байгууллагаас 7210 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 184 нэгж буюу 2.6 хувиар өсчээ.


Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 39 буюу 0.5 хувь нь санал, 7078 буюу 98.2 хувь нь өргөдөл, 93 буюу 1.3 хувь нь гомдол байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдол



Санал, өргөдөл, гомдлыг утгаар нь авч үзвэл: 940 буюу 13.0 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 294 буюу 4.1 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1104 буюу 15.3 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 2198 буюу 30.5 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 329 буюу 4.6 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 2345 буюу 32.5 хувь нь бусад өргөдөл гомдол байна.


Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 7117 буюу 98.7 хувийг шийдвэрлэж, 93 буюу 1.3 хувь нь ажиллагаанд байна.



Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар

2017 оны эхний 9 сард Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 584 өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34 нэгж буюу 6.2 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 3 буюу 0.5 хувь нь санал, 26 буюу 4.5 хувь нь гомдол, 555 буюу 95.0 хувь нь өргөдөл байна.





Иргэд, байгууллагаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 47 буюу 8.0 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 101 буюу 17.3 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 73 буюу 12.5 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 10 буюу 1.7 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 76 буюу 13.0 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 277 буюу 47.4 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Гурав. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төвд ирсэн өргөдөл, гомдол, шүүмжлэл, санал хүсэлтийн талаар

2017 оны эхний 9 сард иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 266 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 143 буюу 53.8 хувь нь санал хүсэлт, 88 буюу 33.1 хувь нь гомдол, 30 буюу 11.3 хувь нь талархал, 2 буюу 0.7 хувь нь шүүмжлэл, 3 буюу 1.1 хувь нь өргөдөл байна.




Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 194 буюу 72.9 хувийг шийдвэрлэж, 72 буюу 27.1 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 135 буюу 69.6 хувийг 5 хоногийн дотор, 59 буюу 30.4 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэжээ.

Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

2017 оны эхний 9 сард иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 1181 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 58 нэгж буюу 4.7 хувиар буурч, 1321 алба хаагч холбогдсоны 1102 буюу 83.4 хувь нь офицер, 214 буюу 16.2 хувь нь ахлагч, 5 буюу 0.4 хувь нь энгийн ажилтан байна. Нийт өргөдөл гомдлын 1104 буюу 93.5 хувийг шийдвэрлэж, 77 буюу 6.5 хувь нь ажиллагаанд шалгагдаж байна.



Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 71 буюу 6.0 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 106 буюу 9.0 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 6 буюу 0.5 хувь нь хэргийн хугацаа хэтэрсэн, 29 буюу 2.5 хувь нь бусдыг чирэгдүүлж танил тал харсан,

8 буюу 0.7 хувь нь хээль хахууль, шан харамж авсан, 271 буюу 22.9 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 65 буюу 5.5 хувь нь бусдыг зодож эрх чөлөөнд нь халдсан, 240 буюу 20.3 хувь нь ажлын хариуцлага алдсан, 21 буюу 1.8 хувь нь архидан согтуурсан, 4 буюу 0.3 хувь нь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 344 буюу 29.1 хувь нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль дүрэм зөрчсөн, 1 буюу 0.1 хувь нь хувцасны болон бусад хангамж дутуу олгосон, 15 буюу 1.3 хувь нь төсвийн хөрөнгө ашигласан зөрчлүүд эзэлж байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС

Зургаа. Санал

1.Өргөдөл гомдлын дүн мэдээг хугацаанд нь ирүүлэх, зөрүүтэй мэдээ ирүүлэхгүй байхад анхаарах, газар, хэлтсийн дарга нар биечлэн хяналт тавих.

2.Иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвөөр дамжуулан цагдаагийн байгууллагад ирүүлж байгаа гомдол, мэдээллийн хариуг төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн дарга нар хугацаа алдалгүй ирүүлж байх шаардлагатай байна.

1.Өргөдөл, гомдлын мэдээ, тайланг гаргаж буй алба хаагчдын ажлын гүйцэтгэлд удирдлагын хяналтыг чиглүүлэх.

2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвөөс ирүүлж буй өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн байдал, түүний эрх зүйн үндэслэл, хариу өгөх хугацаанд тавих хяналтыг сайжруулах.

Зургаа. Санал

1. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, алба хаагчаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээг хугацаа хоцорч ирүүлсэн нэгжийн дарга нар болон холбогдох алба хаагчдад хариуцлага тооцох.

2. Иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвөөр дамжуулан цагдаагийн байгууллагад ирүүлж байгаа гомдол, мэдээллийн хариуг төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн дарга нар хугацаа алдалгүй ирүүлж байх шаардлагатай байгааг илтгэн танилцуулъя.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС

д/д	Хянасан газар, хэлтсийн дарга	Гарын үсэг/огноо	Цол нэр
1	Хянасан: ТЗБХ-ийн дарга		Х/а Б.Батсуурь
2	Хянасан: ТЗБХ-ийн ахлах мэргэжилтэн		Д/х Б.Гантулга
3	Боловсруулсан: ТЗБХ-ийн ахлах мэргэжилтэн		Х/ч Ж.Сайнтод